

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар /цаашид "Газар" гэх/-ын чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлж, үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн тухай хууль, Номын сангийн тухай хууль, Кино урлагийг дэмжих тухай хууль болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын хуульд нийцүүлэн гаргасан захиргааны бусад шийдвэрийг мөрдлөг болгоно.

1.3. Газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан нийслэлийн соёл, урлагийн хөгжлийн стратегийг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, соёл, урлагийн байгууллагыг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангах.

1.4. Газар нь үйл ажиллагааны чиглэлээр төрөлжсөн бүтцийн нэгжтэй байна.

1.5. Эрх бүхий субъектээс баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт багтаан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний ажиллагсадтай байна.

1.6. Газар нь зохих журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд Төрийн сан банкинд харилцах данстай байна.

1.7. Газар нь орон тооны бус мэргэжлийн зөвлөлтэй байж болох ба зөвлөлийн ажиллах журмыг газрын даргын тушаалаар батална.

ХОЁР. ГАЗРЫН ЧИГ ҮҮРЭГ

2.1. Газар нь Соёлын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд үйл ажиллагааны онцлог, нийслэлийн соёлын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн дараах тусгай болон нийтлэг чиг үүргийг энэхүү дүрмийн хүрээнд хэрэгжүүлнэ.

2.2. Газар нь дараах тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1. Нийслэлийн соёл, урлагийн хөгжлийн стратегийг төлөвлөж, хэрэгжүүлэх чиглэлээр:

2.2.1.а. харьяалах нутаг дэвсгэрийн соёлын онцлог, соёлын өв, угсаатны бүлэгт тулгуурласан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлэх;

2.2.1.б. Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль, Музейн тухай хууль, Кино урлагийг дэмжих тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, түүнийг дагаж гарсан дүрэм журмын хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлэлтийг сайжруулах чиглэлээр санал боловсруулж, холбогдох төрийн

2.2.1.в. соёлын талаар батлагдан гарсан хууль тогтоомж болон шинээр батлагдсан эрх зүйн баримт бичгийг сурталчлах;

2.2.1.г. нийслэлийн өмчийн соёл, урлагийн байгууллагын байршил, бүтэц зохион байгуулалтын төлөвлөлт болон шинээр барих, их засвар хийх, өргөтгөх талаар санал боловсруулж, уламжлах;

2.2.1.д. харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд соёлын үйлчилгээ үзүүлэх, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нийслэлийн харьяа соёл, урлагийн байгууллагууд, соёлын төв, соёлын ордны үйлчилгээ, орчныг стандартын шаардлагад нийцүүлэх чиглэлээр төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

2.2.1.е. соёлын ажилтны бүтээлч санаа, шилдэг үйл ажиллагаа, тэргүүн туршлагыг дэмжих, нийтийн хүртээл болгох.

2.2.2. Мэргэжил арга зүй, удирдлагаар хангах чиглэлээр;

2.2.2.а. нийслэлд үйл ажиллагаа явуулж буй бүх төрлийн соёл, урлагийн байгууллагыг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангах, үйл ажиллагаа, үйчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллах;

2.2.2.б. нийслэлийн Засаг даргад соёл, урлагийн чиглэлээр шийдвэр гаргахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.2.2.в. төрийн байгууллагаас бусад соёл, урлагийн байгууллагыг үүсгэн байгуулах, өөрчлөх харилцааны асуудалд хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэх;

2.2.2.г. нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа музей, байгаль, түүх, соёлын үнэт зүйлийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах болон түгээн дэлгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж, ахуйн нэгж, иргэнийг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангах;

2.2.2.д. бүх нийтэд соёлын боловсрол олгох, соёлын бүтээлч үйлдвэрлэл, үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх, эрхлэх чиглэлээр иргэн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх, судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх.

2.2.3. Орон нутгийн өмчийн соёл, урлагийн байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр;

2.2.3.а. орон нутгийн өмчийн соёл, урлагийн байгууллагын удирдах ажилтны албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулах, Төрийн албаны тухай хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагад холбогдох чиглэлээр мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, санал гаргах;

2.2.3.б. соёл, урлагийн байгууллагын хүний нөөцийн мэдээллийн сан үүсгэх;

2.2.3.в. соёл, урлагийн байгууллагын гүйцэтгэх ажилтны томилгоог зохион байгуулахад холбогдох байгууллагуудад нь хууль тогтоомжийн хүрээнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.2.3.г. харьяалах нутаг дэвсгэрийн соёл, урлагийн байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах.

2.2.4. Орон нутгийн соёл, урлагийн байгууллагын мэдээллийн технологи, цахимжилтийн чиглэлээр;

2.2.4.а. цахим шилжилтийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөлт хийх, хэрэгжилтийг хангах;

2.2.4.б. цахим шилжилтийн хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах, харьяа байгууллагын цахимжилтийн талаар төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих, нэгтгэх, тайлагнах;

2.2.4.в. харьяалах нутаг дэвсгэрт соёл, урлагийн байгууллагуудад хэрэгжиж буй цахим шилжилтийн бодлого, төсөл арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтийг хангах.

2.2.5. Улаанбаатар хотод соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр:

2.2.5.а. Улаанбаатар хотын соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр төлөвлөлт хийх, хэрэгжилтийг хангах;

2.2.5.б. Улаанбаатар хотын соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого, чиглэлийн хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах, оролцоог хангах талаар төлөвлөлт хийх, хэрэгжилтэд хяналт тавих, нэгтгэх, тайлагнах;

2.2.5.в. харьяалах нутаг дэвсгэрт соёл, урлагийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, иргэнийг соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бодлого, төсөл арга хэмжээнд хамруулах, оролцоог нэмэгдүүлэх талаар холдбогдох ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангах;

2.2.5.г. Улаанбаатар хотын соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын хөдөлмөр эрхлэгчдийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах.

2.3. Газар нь дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.3.1. Төлөвлөлт, тайлагналт, статистикийн чиглэлээр:

2.3.1.а. газрын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах, төлөвлөгөөний биелэлтийн тайланг гаргах, хяналт-шинжилгээ, үнэлгээг холбогдох хууль тогтоомжид заасан цагалбарт хугацааг баримтлан хэрэгжүүлэх, газрын ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх;

2.3.1.б. стратеги төлөвлөгөө, хууль тогтоомжийн хэрэгжилт, тайлан, мэдээг тогтоосон хугацаанд тайлагнах, хүргүүлэх, дээд шатны байгууллагаас ирүүлсэн хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах;

2.3.1.в. соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон нийслэлийн Засаг дарга нарын хооронд байгуулах хамтран ажиллах чиглэл, гэрээний төсөлд санал өгөх, талуудын хүлээсэн үүргийн хэрэгжилтийг зохион байгуулах;

2.3.1.г. нийслэлийн өмчийн соёл, урлагийн байгууллагын гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, үнэлгээний дагуу авах арга хэмжээний саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх;

2.3.1.д. нийслэлийн өмчийн соёл, урлагийн байгууллагуудад соёлын тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

2.3.1.е. харьяалах нутаг дэвсгэрийн соёл, урлагийн байгууллагын статистик мэдээллийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цуглуулах, нэгтгэн дүгнэх, тайлагнах, мэдээллийн сан бүрдүүлэх;

2.3.1.ё. соёл, урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, санал боловсруулах, цаг үеийн болон зарим шийдвэрийн хэрэгжилтийн талаар шаардсан мэдээллийг шуурхай гаргаж хүргүүлэх, холбогдох

2.3.1.ж. уран бүтээлч, соёлын ажилтанг олон улс, улс, бүсийн чанартай соёл, урлагийн наадам, уралдаан тэмцээн, үзэсгэлэн, яармагт оролцоход дэмжлэг үзүүлэх, холбогдох байгууллагад санал, хүсэлт хүргүүлэх.

2.3.2. Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:

2.3.2.а. төсвийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр төсөвт эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх, нийслэлийн соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжил арга зүй, удирдлагаар хангах;

2.3.2.б. нийслэлийн соёл, урлагийн байгууллагуудын төсвийн төлөвлөлт хийх, харьяа байгууллагын төсвийг нэгтгэн боловсруулах, хүргүүлэх;

2.3.2.в. нийслэлийн өмчит соёл, урлагийн байгууллагын батлагдсан төсвийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих;

2.3.2.г. нийслэл, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй соёлын салбарын эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хуулиар баталсан зориулалт, хүчин чадал, байршил болон эдийн засгийн ангилалын дагуу зохион байгуулах, хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах;

2.3.2.д. харьяалах нутаг дэвсгэрт соёл, урлагийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг хангах;

2.3.2.е. санхүүгийн тайлан тэнцлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу боловсруулан холбогдох газарт хүргүүлэх;

2.3.2.ё. төсвийг ил тод үнэ зөв мэдээлэх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах.

ГУРАВ. ХАРИУЦЛАГЫН ШАТЛАЛ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

3.1. Газар нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан төрийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчмуудаас гадна дараах зарчмыг үйл ажиллагаандаа баримтална:

3.1.1. байгууллагын үнэ цэнэ, нэр хүндийг дээшлүүлж, төрийн үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх;

3.1.2. иргэд, үйлчлүүлэгчид болон хамтран ажиллагч байгууллага, харилцагчдаа дээдлэн хүндэлж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагад хүндэтгэлтэй хандах;

3.1.3. хүнд суртал, авлигал, хээл хахууль, шан харамжаас ангид байх.

ДӨРӨВ. ГАЗРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

4.1. Газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

4.2. Газрын удирдлага нь газрын дарга байна. Газрын даргыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

түр орлон гүйцэтгэнэ.

4.4. Газрын даргын дэргэд байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар түүнд зөвлөх, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий олон нийтийн зөвлөлтэй байж болно. Олон нийтийн зөвлөлийн ажиллах журмыг Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын хүрээнд ажиллуулна.

4.5. Газрын хариуцсан чиг үүрэгт хамаарах нийслэлийн хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах, батлуулах, салбар дундын уялдааг хангах, зохицуулах, хяналт тавих, захиргааны эрх хэмжээний асуудлаар зөвлөмж, чиглэл өгөх, мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих асуудалд Төрийн захиргааны төв байгууллага болон нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өгсөн чиглэлийн дагуу ажиллана.

4.6. Газрын хариуцсан чиг үүргийн хүрээнд төрийн захиргааны төв байгууллага болон нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах, өгсөн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг газрын дарга хариуцан хэрэгжүүлнэ.

ТАВ. СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Газрын өдөр тутмын үйл ажиллагааг дарга удирдан зохион байгуулна.

5.2. Газрын дарга нь дараах бүрэн эрх, үүрэгтэй:

5.2.1. дарга нь хууль тогтоомжид заасны дагуу төсвийн шууд захирагчийн болон энэхүү дүрмийн 2.2, 2.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;

5.2.2. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, удирдах, гүйцэтгэлийг хангах, хяналт тавих;

5.2.3. хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон нийслэлийн Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг дээд шатны байгууллага, албан тушаалтны өмнө хариуцах;

5.2.4. хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, газрын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг батлах;

5.2.5. газрын болон ажилтан, албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

5.2.6. газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

5.2.7. холбогдох хууль тогтоомжид заасан эрхийн хүрээнд байгууллагын ажилтнуудыг томилж, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах;

5.2.8. соёлын ажилтныг шагнаж урамшуулах, төр, засгийн шагналд тодорхойлох;

5.2.9. үйл ажиллагааны чиглэлээр гадаад харилцааг өргөжүүлэх, гадаад болон дотоодын ижил төрлийн байгууллагуудтай хамтран ажиллах, гэрээ хэлцэл хийх, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас чиглэл авах;

5.2.10 хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1. Албан ажилдаа хариуцлагагүй хандсаны улмаас бусдын хууль ёсны эрх ашгийг хохироосон, гүйцэтгэлийн төлөвлөгөө болон энэ дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн ажилтан, албан хаагчид Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хууль, дүрэм, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ДОЛОО. БУСАД

7.1. Газар нь улсын болон орон нутгийн төсөв, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжнэ.

7.2. Энэ дүрмээр нарийвчлан зохицуулагдаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

7.3. Дүрэмд Соёлын сайдын тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

7.4. Дүрэм батлагдсанаар хууль тогтоомжид заасны дагуу Улсын бүртгэлд бүртгүүлнэ.

7.5. Энэ дүрмийг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.